


ЗАВХАН АЙМГИЙН 2021 ОНЫ УС ЦАГ УУР, ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ



**МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ
ЦАГ УУР
ХӨДӨӨ АЖ АХУЙН ЦАГ УУР
УС СУДЛАЛ
ЛАБОРАТОРИ
ЗАВХАН БОРОО ЭКСПЕДИЦ**

Агаарын температурын хувьд:

Агаарын дундаж температурын хазайлт
/ I-XII сар /




Аймгийн хэмжээнд энэ жилийн дундаж агаарын температур 0.9 градус хүйтэн буюу сүүлийн 30 жилийн дунджаас дулаан жил болсон байна.

Агаарын дундаж температурыг сар бүрээр нь олон жилийн дундажтай харьцуулж үзэхэд V, VI, VIII, X саруудад дунджийн орчим байсан ба I-IV, VII, XI, XII сард 1.8 - 3.8 градусаар дулаан байсан бөгөөд II сард ОЖД-аас 8 градусаар дулаан байсан нь онцлог болж өнгөрчээ.



Завхан аймгийн 2021 оны Агаарын хамгийн их температур

Агаарт VI-VII саруудад
говь талын сумдаар 30-34 градус
хүрч дулаарсан ба 30 градус буюу
түүнээс дээш дулааралт
12-17 өдөр ажиглагдсан байна.



Завхан аймгийн 2021 оны Агаарын хамгийн бага температур


Хамгийн их хүйтрэлт
Отгон суманд 1/4-нд -47.2
хүрч хүйтэрсэн байна.



Хөрсний гадаргын температурын хувьд:

Хөрсний жилийн дундаж температур хангайн уулархаг нутгаар $0.0...-1.0^{\circ}\text{C}$, бусад нутгаар $2.0...8.0^{\circ}\text{C}$ байсан байна.


Завхан аймгийн 2021 оны
Хөрсний хамгийн их температур




Зарим сумдад хөрсний
термометр байхгүй.




Завхан аймгийн 2021 оны
Хөрсний хамгийн бага температур



Зарим сумдад хөрсний
термометр байхгүй.




Хур тунадасны хувьд:




- Аймгийн хэмжээнд 2021 оны жилийн нийлбэр тунадас 235.1мм буюу олон жилийн дунджаас ялимгүй ахиу тунадас орсон байна.
- Жилийн турш нийт нутгаар тунадас багатай байсан ба жилийн нийлбэр тунадасны ихэнх хувийг IV сарын 23-24нд орсон аадар тунадас, VIII сарын 1, 17, 21-22-ны өдрүүдэд орсон аадар борооны хэмжээ эзэлж байгаа ба энэ нь нийлбэр тунадасны хэмжээг огцом нэмэгдүүлж олон жилийн дунджаас ахиу орсон тооцоо харагдуулж байна.

Завхан аймгийн 2021 оны Хоногт орсон хамгийн их хур тунадас




Дөрвөлжинд VIII/17-нд 45.2 мм,
Эрдэнэхайрханд VIII/1-нд 43.5 мм
хур тунадас орсон байна.




1:2,100,000

Салхи:

Энэ жил IV, V сард нийт нутгаар сарын ихэнх өдөр, VI сард говь талын нутгаар сарын ихэнх өдөр нь 10м/с-ээс их салхитай байсан ба нийт 95-153 өдөр нь харьцангуй салхирхуу байсныг харуулж байна.



Цасан бүрхүүлийн тойм:




- Жилийн эхээр цасны зузаан харьцангуй бага байсан ба хамгийн их нь 1-2 дугаар сард Баянтэс, Яруу, Цагаанхайрхан, Цагаанчулуут сумдын нутгаар 12-16см, бусад нутгаар 1-10см цастай байсан байна. Харин говийн сумд, Эрдэнэхайрханы баруун хэсэг, Нөмрөгийн нутгаар цасгүй байсан байна.

2021 оны сүүлийн цасан бүрхүүлийн байдал




- Жилийн сүүлчээр буюу 12 дугаар сард мөн л цас багатай цасны зузаан хамгийн ихдээ Тосонцэнгэл, Цагаанхайрханд 9см, Баянтэс, Ярууд 6см, Улиастайд 5см, бусад нутгаар 0-4см цастай харин Дөрвөлжин, Шилүүстэй, Цагаанчулуутад цасгүй байсан байна.


БЭЛЧЭЭРИЙН УРГАМЛЫН УРГАЦ Ц/ГА




Ойт хээрийн бүс нутгийн бэлчээрийн ургамлын бүрхэцийн үнэлгээ /2010-2021 он/




Тал хээр хэрийн бүс нутгийн бэлчээрийн ургамлын бүрхэцийн үнэлгээ /2010-2021он/



Цөлжүү хээрийн бүс нутгийн бэлчээрийн ургамлын бүрхэцийн үнэлгээ /2010-2021 он/




■ Nogoön ■ Hagd ■ Haltsgai



Аймгийн хэмжээнд зуншлагын байдал 2021 оны 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгийн 80 орчим хувьд сайн, 20 хувьд дунд зэргийн зуншлагатай байлаа. Ихэнх нутгаар 5, 6 дугаар сард халуун хуурай салхитай, хөрсний чийгийн хангамж муу байгаагаас хуурайшилт ихтэй ургамлын үе шат удаашралтай, гэмтэл ажиглагдсан 7 дугаар сард ихэнх нутгаар их бага хэмжээний тунадас орж ургамлтын байдал сэргэж бэлчээрийн ургамлын ургалтын байдал сайжирсан.

БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН АЖИГЛАЛТЫН СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН УРГАЦ Ц/ГА



2019-2021 ОНЫ ӨВӨЛ, ХАВРЫН БЭЛЧЭЭРИЙН ДААЦЫГ ТОДОРХОЙЛСОН ДҮН

Монгол улсын Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2019-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн тооцоолж гаргав.

Бэлчээрийн нөөцтэй 41%


Бэлчээр хүрэлцээтэй 30%

Даац 1-3 дахин хэтэрсэн 17%

Даац 3-5 дахин хэтэрсэн 2%

Даац олон дахин хэтэрсэн 10% ийм байна.

2021-2022 оны өвөл-хаврын бэлчээрийн даац, % (багийн нутгаар)



2021 онд агаарын дундаж температур 0, 5,10 градусыг дайрч тогтвортой шилжих хугацаа

Агаарын дундаж температур 0, 5, 10 градусыг дайрч тогтвортой шилжих хугацааг тодорхойлж, олон жилийн дундажтай харьцууллаа.

Хавар

- 0 градусыг дайрч тогтвортой шилжсэн хугацаа 3 хоногоор хожуу
- 5 градусыг дайрч тогтвортой шилжсэн хугацаа 4 хоногоор эрт
- 10 градусыг дайрч тогтвортой шилжсэн хугацаа 6 хоногоор хожуу **Намар нь**
- 0 градусыг дайрч тогтвортой шилжсэн хугацаа 1 хоногоор эрт
- 5 градусыг дайрч тогтвортой шилжсэн хугацаа 2 хоногоор хожуу
- 10 градусыг дайрч тогтвортой шилжсэн хугацаа хангайн уулархаг нутгаар 10 хоногоор эрт, говийн бүс нутгаар 21 хожуу ажиглагдсан байна.
- 0 градусыг дайрч тогтвортой дулаарсан хоногийн тоо 4 хоног
- 5 градусыг дайрч тогтвортой дулаарсан хоногийн тоо 6 хоног
- 10 градусыг дайрч тогтвортой дулаарсан хоногийн тоо говийн бүс нутгаар 21 хоног уртссан бол хангайн уулархаг нутгаар 11 хоногоор богиноссон байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ



1



АГААР

2



УС


3




ХӨРС



СУУРИН ЦЭГТ: АГААР БОХИРДУУЛАХ БОДИС ХҮХЭРЛЭГ ХИЙН 620 СОРЬЦ, АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН 620 СОРЬЦ НИЙТ 1240 СОРЬЦОНД ХЭМЖИЛТ ХИЙГДСЭН.



- ✓ ХҮХЭРЛЭГ ХИЙН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ 3-45МКГ/М³, САРЫН ЯВЦ НЬ 1, 2 САРД БУСАД САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖААС БОХИРДОЛ ИХ БАЙНА. ХҮХЭРЛЭГ ХИЙ 1 САРД ХОНОГИЙН ХАМГИЙН ИХ НЬ 153МКГ/М³ БАЙНА.




- ✓ АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ 5-57МКГ/М³, САРЫН ЯВЦ НЬ 10, 11-12 САРД БУСАД САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖААС ИХ БОХИРДОЛТОЙ БАЙНА. АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН ХОНОГИЙН ХАМГИЙН ИХ НЬ 10 САРД 235 МКГ/М³ БАЙЛАА



Улиастай сумын
агаарын чанарын
сүүлийн 7 жилийн
өөрчлөлт



PM10 тоосонцорын сарын дундаж агууламж




⇒ Тоосонцорын/PM10/-ын хэмжилтийг DUST TRAK багажаар жилд нийт 218 удаа хэмжилт хийсэн.

Хэмжилтийн дүнгээс харахад сарын дундаж агууламж 12-69 мкг/м³ хэлбэлзэлтэй жилийн дундаж агууламж 37 мкг/м³.

MNS4585:2016 стандарттай харьцуулахад жилийн хэмжээнд 8 удаа стандартаас 1-1.9 дахин тус тус стандартаас давсан тухайн бохирдолтой сар нь 1-3 болон 11 сард ажиглагдсан байна.

PM 2.5 тоосонцорын сарын дундаж агууламж



⇒ PM2.5 тоосонцор 169 удаагийн хэмжилт хийгдсэн.


Хэмжилтийн дүнгээс харахад сарын дундаж агууламж 6-68 мкг/м³ хэлбэлзэлтэй жилийн дундаж агууламж 29 мкг/м³.

MNS4585:2016 стандарттай харьцуулахад жилийн хэмжээнд 16 удаа стандартаас 1-1.7 дахин давсан тухайн бохирдолтой сар нь 1-3 болон 12 сард ажиглагдсан байна.



ЯВУУЛ СУДАЛГАА

ӨДӨР ТУТМЫН ШИНЖИЛГЭЭНЭЭС ГАДНА УЛИАСТАЙ СУМАНД ЯВУУЛЫН ДЭЭЖ АВАХ ЦЭГ СОНГОН АВЧ ЖАРГАЛАНТ, ЖИНСТ, БОГДЫН ГОЛ БАГИЙН ОРЧМООС 01-04, 11,12 САРУУДАД ХҮХЭРЛЭГ ХИЙ, АЗОТЫН ДАВХАР ИСЭЛ, ТООСОНЦОР/PM10/-Н ХЭМЖИЛТҮҮД ХИЙГДСЭН.



MNS4585:2016 стандарттай харьцуулахад хүхэрлэг хийн дундаж агууламж жинст орчимд 21-45 мкг/м³буюу 1,6дахин, богдын гол орчимд 16-34 мкг/м³буюу 1.4дахин, жаргалант орчимд 12-49мкг/м³1.5 дахин давсан үзүүлэлттэй байна.




MNS4585:2016 стандарттай харьцуулахад азотын давхар исэлийн дундаж агууламж жаргалант орчимд 18-141 мкг/м³буюу 1.5 дахин, жинст орчимд 31-57 мкг/м³ буюу 1.3 дахин, богдын гол орчимд 20-119 мкг/м³буюу 1.2 дахин стандарт агууламжаас давсан үзүүлэлттэй байна.



MNS4585:2016 стандарттай харьцуулахад тоосонцор/PM10/-ын дундаж агууламж богдын гол орчимд 78 мкг/м^3 буюу 1.6, жаргалант орчимд 98 мкг/м^3 буюу 1.9 дахин их харин жинст орчимд 47 мкг/м^3 буюу стандартаас даваагүй болно.

Цацрагийн хяналт шинжилгээ

Завхан аймгийн Улиастай, Баянтэс сумуудын орчны цацрагийн хэмжилтийг RDS-110 багажаар тодорхойллоо. Улиастай өртөөнд нийт-1 хэмжилт Баянтэс өртөөнд нийт-1384 хэмжилт хийгдсэн.



Хэмжилтийн дүнгээс харахад $0.09-0.13$ микрозевирт/цаг хязгаарт хэлбэлзэж байна. Энэ нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, зөвшөөрөгдөх хэвийн хэмжээнд байна.

Агаар дахь тунадас тоосонцрын нийлбэр бета идэвхи





ЭХ ҮҮСВЭРИЙН НЭГДСЭН ТООЛЛОГО ДҮН

- 2021 ОНД ЗАВХАН АЙМГИЙН ХЭМЖЭЭНД НИЙТ АГААР БОХИРДУУЛАГЧ 10010 АЙЛ ӨРХ, 6086.7ТН НҮҮРС, 87595.2М³ МОД, 225.75ТН САЙЖРУУЛСАН ТҮЛШ, 1398.7ТН БУСАД ТҮЛШ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Агаар бохирдуулах бодисын хаягдлын тооллого:

№	Сумдын нэр	Тоо	SO ₂ /тн/	NO _x /тн/	TSP /тн/	PM10 /тн/	PM2.5 /тн/	CO /тн/
1	Алдархаан	85	8.343779	2.00065	11.312902	10.6212395	9.6499145	36.1230095
2	Асгат	117	4.6804475	2.3932825	11.0704625	10.51921125	9.92445875	44.89061125
3	Баянтэс	377	11.0527125	4.7881875	20.2788375	19.27246875	18.12448125	97.44841875
4	Баянхайрхан	179	12.59365	6.362	20.92865	19.530575	18.401625	111.588075
5	Дөрвөлжин	243	61.9906	10.795479	76.32009	72.375618	65.2895	297.09443
6	Завханмандал	151	7.944143	2.23827	15.21575	14.123194	13.46761	80.985341
7	Их-Уул	642	21.89184	14.8428	44.23664	41.09648	39.25104	246.55232
8	Идэр	236	6.292163	2.8659375	12.02879	11.428719	10.77683	58.020019
9	Нөмрөг	241	7.91467	3.40886	14.46262	13.744415	12.92297	69.479795
10	Отгон	331	11.8567	4.808299	14.80943	13.314979	12.76245	100.72372
11	Сантмаргаз	202	6.820563	2.3812275	13.1168	12.444689	11.5766	47.111309
12	Сонгино	239	7.89154	5.15187	20.88175	19.83588	18.85266	102.46462
13	Түдэвтэй	209	8.732195	4.6516	19.24028	18.254148	17.35652	94.999098
14	Тэс	352	10.03265	3.1625525	14.77086	14.018956	13.00749	69.709876
15	Тэлмэн	225	8.484113	4.7200375	19.53049	18.517994	17.65086	96.903594
16	Тосонцэнгэл	1345	22.67895	21.39585	72.87745	68.730325	66.49748	373.26793
17	Улиастай	3962	130.379235	38.26595744	249.8588703	234.6969845	223.3390251	830.0212128
18	Ургамал	90	6.96465	1.5245863	11.09558	10.450753	9.632378	39.719943
19	Цагаанхайрхан	83	3.895203	1.2664575	7.276428	6.8921988	6.407511	26.473259
20	Цагаанчулуут	111	5.030765	1.2646	8.07511	7.6236075	7.039933	29.861133
21	Цэцэн-Уул	163	5.710725	4.226465	13.39443	12.503888	12.00839	68.804708
22	Шилүүстэй	216	7.45460375	2.03485625	7.93399125	7.270268125	6.766396875	47.23111813
23	Эрдэнэхайрхан	117	8.955334	2.5075118	7.190999	6.6916688	6.343131	60.006256
24	Яруу	94	3.289543	1.8515275	5.178718	4.7463788	4.493591	26.692499



24 сумын 3-15кВт хүртэл хүчин чадалтай 10010 айл өрх, аж ахуй нэгж, 15-100кВт хүртэл хүчин чадалтай зуух ашигладаг 115 аж ахуй нэгж, 101-4200кВт хүчин чадалтай зуух 36 тоологдсон ба аймгийн хэмжээнд нийт 10161 зуух 91712.5м³ мод, 40493.2тн нүүрс, 225.75тн сайжруулсан түлш, бусад 1398.7тн түлш хэрэглэн хичнээн хэмжээний хаягдал агаарт хаягдаж буйг тооцон дараах хүснэгтээр харуулав.




Гадаргын усны төлөв


Гадаргын ус судлалын хяналт шинжилгээний хүрээнд нийт 8 голын 13 харуул, 1 нуурын усны найрлага, чанарын байнгын ажиглалт хэмжилт хийж гол, харуулын зэрэглэлээс хамааран усны сорьцыг жил тутам 1-12 удаа авч химийн найрлагын Ca^{2+} , Mg^{2+} , $\text{Na}^{+}+\text{K}^{+}$, HCO_3^{-} , SO_4^{2-} , Cl^{-} усанд ууссан хийг O_2 биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, перманганатын исэлдэх чанар, шим бохирдлын $\text{NH}_4\text{-N}$, $\text{NO}_2\text{-N}$, $\text{NO}_3\text{-N}$, $\text{PO}_4\text{-P}$ мөн Fe, F, Cr-6, pH зэрэг физик, химийн байгалийн дэвсгэр бохирдлын 20-оод үзүүлэлтийг Байгаль орчны шинжилгээний лабораторид шинжилж байна.



Усны хатуулаг /2011-2021он/



Усны эрдэсжилт / 2011-2021 он /



Усны хатуулаг чанар. Усны хатуулгаар маш зөөлөн ангилалд - Богд гол, Чигэстэй гол, Буянт гол, Идэр гол /Идэр сум/, Идэр гол/Тосонцэнгэл сум/, зөөлөн ангилалд - Тээл гол, Завхан гол, Хар нуур, Хүнгүй дунд зэрэг ангилалд – Тэс гол голууд багтаж байна.

Усны эрдэсжилтээр маш бага эрдэсжилттэй ангилалд - Богд гол, Чигэстэй, Буянт гол, бага эрдэсжилттэй ангилалд – Идэр гол, дунд эрдэсжилттэй ангилалд – Тэс гол, Хүнгүй гол, Завхан гол, Тээл гол, Хар нуур багтаж байна.



Усны чанарын индексээр үнэлэхэд



Усны чанарын үнэлгээ	I Маш цэвэр	II Цэвэр	III Бага бохирдолтой	IV Бохирдолтой	V Бохир	VI Маш бохир
Индекс	≤0.3	0.31-0.89	0.90-2.49	2.50-3.99	4.00-5.99	6≤
2020 он	4					
Усны объект-харуул	Буянт, Тэс, Завхан	Богд гол, Чигэстэй гол, Хүнгүй, Тээл, Хар нуур				
2021 он	6	7				
	Идэр гол, Тэс гол, Идэр-Тосон, Завхан гол, Хар нуур	Чигэстэй гол, Богд Буянт гол, Хүнгүй гол, Тээл гол				

Бохирдлын индекс	Усны чанар	
	Зэрэг	Ангилал
≤0.3	I	Маш цэвэр
0.31-0.89	II	Цэвэр
0.90-2.49	III	Бага бохирдолтой
2.50-3.99	IV	Бохирдолтой
4.00-5.99	V	Бохир
6≤	VI	Маш бохир

➔ Усны чанарын индексээр манай аймгийн 8 гол, 1 нуурын ус нь I, II дугаар зэрэгт багтаж байна. Усны бохирдлын индексээр үнэлэхэд 2021 онд Идэр, Тэс, Завхан голууд болон Хар нуурын ус I-р зэрэг маш цэвэр, Богд, Чигэстэй, Хүнгүй, Буянт, Тээл голуудын нуурын ус II-р зэрэг цэвэр ангилалд тус тус багтаж байна. Буянт голын ус I-р зэргээс II-р зэрэгт шилжсэн байна.



Цэвэрлэх байгууламжийн шинжилгээний дүн

Завхан-Цэвэрлэх байгууламжийн гарах, орох нийт 24 сорьцонд 156 химийн шинжилгээнүүдийг тодорхойлов.



Цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн усыг **MNS4943:2018** стандарттай харьцуулахад биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 1-6, 9, 11 саруудад 1.1-5.7 дахин, жинлэгдэгч бодис 4, 6, 10 саруудад 1.0-1.9 дахин, нийт азот нь 1-6 саруудад 1.2-2.7 дахин их давсан үзүүлэлттэй байна.

✓Завхан аймгийн Улиастай сумын хөрсний бохирдлыг хөтөлбөрийн дагуу 3 цэгээс сорьц авч, агрохими, хүнд металлын хяналт шинжилгээг хийж гүйцэтгэлээ.



Хүнд металлын дүнгээс харахад: Уурын зуух орчмын цайрын болон стронцын агууламж тус тус 1.9 дахин их бохирдолтой байна.


Урвалын орчин:

Хөрсний урвалын орчин 6.28-9.12-ийн хооронд байна. Улиастай сумын хөрс нь сул хүчиллэг болон шүлтлэг орчинтой байна.

Хөрсний ялзмаг:

Ялзмаг нь хөрсний үржил шимийг тодорхойлох үндсэн үзүүлэлт болдог. Хөрсөнд хэдий чинээ их ялзмагтай байна, төдий чинээ ус, агаар, дулаан, физик- химийн шинж чанар нь сайн байна. Шинжилгээнд хамрагдсан сорьцнуудын хувьд ялзмагийн агууламжийн хувь нь 0.286-4.784 хооронд байна. Иймд ялзмаг багатай хөрсөнд орж байна. Мөн чийгийн коэффициент 1.00-1.12%, сульфатын агууламж 82.15-1322.2 мг/кг, фосфорын агууламж 49.16-427.88 мг/кг, нитратын агууламж 10.22-85.47 мг/кг, аммоны агууламж 1.71-27.88 мг/кг байна.

Гадаргын ус судлалын өртөө




Гадаргын ус судлалын 14 харуулд Усны түвшин, өнгөрөлт, газар доорхи ус, цэвдэг, автомат түвшин, хими, биологийн дээж, температур, тунадас хэмжигч мөн булингар, гольдрилын хэмжилтийг тус тус хийж төлөв байдлыг тодорхойлж байна.

Ус судлалын харуулын байршил

НЭГДСЭН ЗУРАГЛАЛ РЕКИ-РЕЖИМ – 2021ОН

Комплексный график результатов гидрометеорологических наблюдений за 2019 г.
Пост 11071. Буюнт гол-Отгон сум



Агаар температур t^0

Тунадас /мм/

Усны температур t^0

Мөсөн дээрх цасны зузаан /см/

Мөсний зузаан /см/

Мөсний үзэгдэл

Усны түвшин /см/

Өнгөрөлт /м³/с/,


УРСАЦ-2021ОН

Мөн жилийн УД-1, УД-2 дэвтрүүдийг нэгдсэн зураг, хамаарлын муруйд зурж боловсруулан жилийн урсацыг гаргадаг.

Нэгдсэн зурагт; өвлийн өнгөрөлт, усны түвшин, мөсний зузаан, цасны зузаан, усны температур, үзэгдэл, тунадас, агаарын температурыг зурж боловсруулдаг.

Хамаарлын муруй; Хамаарлын муруйг гол цэвэр чөлөөтэй үеийн өнгөрөлтөөр хатгах бөгөөд өнгөрөлт, усан огтлолын талбай, хурд, өмнөх оны талбай, шалгалтын өнгөрөлт, өнгөрөлт боловсруулсан сар, өдөр, хамаарлын хувь зэргийг хатган боловсруулдаг.

Завхан-Дэрвөлжин 2019-2021 оны урсацын харьцуулалт



Биологийн дээж

Амьтан, ургамлын дээжийг 6 харуулаас 5-9 сард нийт 30 биологийн дээжийг авч Ус судлалын секторийн биологийн дээжинд явуулж шинжилгээгээр цэвэр ангилалд багтаж байна.



Цэвдэг

Тосонцэнгэл, Идэр, Отгон сумдын цэвдгийн мэдээллийг жилд нэг удаа НОВО програмаар хураан авч Гадаргын ус судлалын хэлтэст хүргүүлсэн.


Газар доорхи ус

Газар доорхи усны 4 цооногт сар бүр 3 удаа усны түвшин, температурын ажиглалтын мэдээг Гадаргын ус судлалын хэлтэст хүргүүлсэн.



Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа.

Хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг “Завхан Бороо-1” экспедиц 4 дүгээр сарын 10, 23, 5 дугаар сарын 13, 20, 21, 6 дугаар сарын 05, 12, 27, 28, 7 дугаар сарын 2, 8 -ны өдрүүдэд 10 удаа, газрын генератор 3 удаа, нийт 13 удаагийн үйл ажиллагаа явуулсан.




Үр дүн


4 дүгээр сард: Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг 2 удаа явуулсан аймгийн хэмжээнд нийлбэр тунадас 469.5мм буюу олон жилийн дунджаас ахиу хур тунадас орсон.

5 дугаар сард: Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг 3 удаа явуулсаны үр дүнд аймгийн хэмжээний нийлбэр тунадас 237.7мм буюу олон жилийн дунджийн орчим хур тунадас орсон.

Нийлбэр хур тунадасны хазайлт
/ 2021 оны 04 сар /



Сарын нийлбэр хур тунадасны хазайц
/ 2021 оны 05 дугаар сар /




Үр дүн


6, 7 дугаар сард: Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг 6 удаа явуулж аймгийн хэмжээнд нийлбэр тунадас 6-н сард 300.8мм, 7-н сард 1280,7мм буюу ихэнх нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас орсон.


8 дугаар сард: Аймгийн хэмжээнд нийлбэр тунадас 2351.4мм буюу нийт нутгаар олон жилийн дунджаас 1-5 дахин их хур тунадас орсон.

Нийлбэр хур тунадасны хазайлт
/ 2021 оны 07 сар /



Нийлбэр хур тунадасны хазайц
/ 2021 оны 08 дугаар сар /





- ХАНДУУЛСА
НД

<http://zavkhan.tsag-agaar.gov.mn/> сайт,
Завхан Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэл-
<https://www.facebook.com/Zavkhan.tsaguur> хуудсанд нэгдээрэй.

УЦУОШТӨВ